

## Дараах тодорхойлолтыг зөв болгоно уу?

1. Байгальд орших, тодорхой химийн найрлагатай, оронт торны бүтэцтэй? Органик бус, хатуу биет ..... юм.
2. Нэг юмуу, хэд хэдэн эрдсийн агрегат нийлж эрдэс үүсгэнэ. Дээрх тодорхойлолт ..... байна.
3. Чулуулгийг гарал үүлсээр нь магмын, ....., хувирмал гэж ангилна.
4. Чулуулгийн шинжийг гэрэл зурагтай нь зөв харгалзуулна уу?

$\text{CaSO}_4 \cdot 2\text{H}_2\text{O}$ . Хатуулаг 1,5-2,0. Нягт 2,2-2,4. Өнгө: цагаан цайвар хөх, цайвар саарал, зураасны өнгө нь цагаан, шилэн гялгатай. Бүрэн гүйцэт хагаралтай. Давсны хүчлд уусдаггүй, хумсаар маш сайн зурагдана, зөөлөн.



Хээрийн жонш, кварц, гялтгануураас бүрэлддэг гүний чулуулаг. Гялтгануурын өнгнөөс хамаарч, саарал, улаан, ногоовтор цайвар өнгөтэй. Бат бөх чанартай барилга, техникт өргөн ашиглана.



$\text{SiO}_2$  цахиурын исэл. Хатуулаг 7. нягт 2,6-2,8. Өнгө: тунгалаг, хүрэн, саарал гэх мэт янз бүр. Хатан чанартай, цохиход бутарч үйрдэг, металл биш эрдэс, дун маягийн хагаралтай. Шилэн гялгатай, зураас нь цагаан.



5. Чулуулгийн гэрэл зургийг ажиглан зөв нэрийг өгнө үү?



Гантиг                  Нүүрс                  Кварцит                  Боржин                  Гипс                  Пемза

6. Чулуулгийг бүрдүүлэгч эрдсүүдийн үнэмлэхүй ба харьцангуй хэмжээ, хэлбэр дүрс, өөр хоорондоо ургаж тогтох харьцаагаар тодорхойлогддог чулуулгийн бүтцийн онцлогийг ..... гэдэг.
7. Чулуулгийг бүрдүүлэгч эрдсүүдийн орон зайн байрлалаар тодорхойлдог шинжийг ..... гэнэ.
8. Текстурийн шинжүүд нь гарш, томоохон дээжинд сайн илэрдэг учир тогтооход хялбар байдаг. Үелэг ба жигд текстур онцлогтой. Энэ ..... чулуулгийн текстур юм.

9. Магмын чулуулгийг бүрдүүлэгч эрдсүүдийн мөхлөгийн хэмжээгээр маш том мөхлөгт (мөнхлөгийн хэмжээ 10мм-ээс их), том мөхлөгт (10-3мм), дунд мөхлөгт (3-1мм), жижиг мөхлөгт(1мм-ээс бага). Энэ нь ..... чулуулгийн текстур.

10. .... чулуулгийг гол эрдсүүдийн мөхлөгийн хэмжээгээр нь:

- Микромөхлөгт (0.01-0.1 мм)
- Жижиг мөхлөгт (0.1-1.0 мм)
- Дунд мөхлөгт (1,0-5.0 мм)
- Том мөхлөгт (5,0-10,0 мм)
- Маш том мөхлөгт (10 мм-ээс их) гэх мэт структур ялгагдана.

11. Чулуулгийн текстур тодорхойлох аргийг зөв харгалзуулна уу?


Хувирмал чулуулгийн  
текстур



Магмын чулуулгийн  
текстур



Тунамал чулуулгийн  
текстур



12. Доорх чулуулгуудийг гарал үүслээр нь харгалзуулна уу?



магма



тунамал



хувирмал